



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар A)203

Хэрлэн сум

Хяналт, шалгалт хийх
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тариалангийн зориулалтаар газар эзэмшиж буй иргэн, аж ахуйн нэгжүүдийн судалгааг гаргаж, нэгж талбарын хувийн хэрэгт хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах ажлыг Мөрөн, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Өмнөдэлгэр, Биндэр, Дадал, Баян-Адарга, Норовлин, Батноров, Хэрлэн сум, Хурх тосгонд 2023 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөс 2023 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр хүртэлх хугацаанд хэрэгжүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Б.Дарханбаатар

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн
дарга:

Г.Ариунчимэг

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хөгжлийн бодлого, төлөвлөлт,
хөрөнгө оруулалтын хэлтсийн
мэргэжилтэн

Гишүүд:

Ж.Энх-Амгалан

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Б.Мөнхчимэг

Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Газрын
удирдлагын хэлтсийн даргын түр
орлон гүйцэтгэгч

Сумын Засаг дарга нар

Сумын газрын даамал

2. Дээрх ажлыг үр дүнтэй зохион байгуулж, биелэлтийг танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Дарханбаатар)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ЧОГСОМЖАВ